



АУДИТЫН КОД: САГ-2018/29/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Хонгорзул

Утас: 260512 Цахим хаяг: khongorzull@audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа

Утас: 260512 Цахим хаяг: nyamdavaan@audit.gov.mn

Гэрээт аудитор Б.Даваабаатар


Утас: 260512 Цахим хаяг:

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	8
3	АУДИТЫН ТАЙЛАН	10
3.1	Оршил	10
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	10
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	11
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	11
3.5	Дотоод аудит	12
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	13
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	14
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	14
3.9.1	Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар:.....	14
3.10	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар:	16
3.11	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	17
3.12	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	17
3.13	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	17
3.14	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.15	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	18
3.16	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	18
3.17	Үр өгөөжийн тооцоолол	18
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	19
4.1	Худалдан авах ажиллагааны талаар	20
4.2	Зардлын талаар	21
4.3	Эздийн өмчийн талаар.....	22
4.4	Зорилтот түвшингийн талаар	22
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	23
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	23
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	24
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	25
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	26
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	27
6	АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГС ААЛТ	28
7	АЛБАН ШААРДЛАГА.....	33





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Ц.ДАВААСҮРЭН ТАНАА

2018.04.25 № 1027

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110.10.10.2018chig_khereglawsan_bichig120180425SAG16.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

070425

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д. ХҮРЭЛБААТАР

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ОРШИЛ

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Эрчим хүчний яамны санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын худалдан авах ажиллагаа, зардал, эздийн өмч, зорилтот түвшингийн талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 9-нөөс 2018 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Н.Нямдаваа, гэрээт аудитор Б.Даваабаатар хариуцаж хэрэгжүүлэв.



Эрчим хүчний сайд 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн б/1185 дугаар дугаар албан бичгээр Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Эрчим хүчний сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах;
- Эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, бүс нутгийн шугам сүлжээ байгуулах;
- Эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай, аюулгүй байдлыг хангах;
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;
- Эрчим хүчний эх үүсвэрүүдийн түлшний баланс гаргах замаар нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг өргөжүүлэх;
- Эрчим хүчний нүүрсний болон шинэ, хийн түлшний технологийг хөгжүүлэх, инновацийг дэмжих;
- Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх;
- Эрчим хүч, түлш (эрчим хүчний нүүрс)-ний салбарт шинжлэх ухаан, технологи, эрчим хүчний балансын судалгаа, стандарт, норм, нормативын баримт бичиг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зэрэг болно.

Эрчим хүчний сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.


Эрчим хүчний яам тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Эрчим хүчний сайдын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах гурван арга хэмжээ төлөвлөснөөс 83.3 хувийн биелэлттэй байна. Үүнд:

- Дулааны шугам сүлжээний өргөтгөл арга хэмжээ;
- Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлт;
- Орон нутгийн цахилгаан хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлт.

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан болно.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын



стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Эрчим хүчний яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 10 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эрчим хүчний сайдын 2017 оны 3 дугаар сарын 27-ний өдрийн 46 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит


Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаж дотоод хяналтын эрсдлийг бага гэж үнэллээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Эрчим хүчний яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж ажилласан байна.

Эрчим хүчний яамны дотоод аудитын хорооны 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Дотоод аудитын 2017 оны төлөвлөгөө, төсөв бэлтгүүлсэн байна. Төлөвлөгөөний дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллага болон



яаманд хэрэгжүүлж буй гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн урсгал зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалт, бүртгэл тайлагнал, санхүүгийн бусад үйл ажиллагаанд дотоод аудит хийжээ.

Хүснэгт №1 Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	8	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	8	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	53	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	-
		Дүн (сая.төг)	26,944.1
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	95
		Дүн (сая.төг)	26,944.1

Эх сурвалж: Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 оны тайлан.

Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөх, авлага, өглөгийг, бууруулах, тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах, шилэн дансны хэрэгжилтийг хангах, дотоод хяналтыг сайжруулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж байх зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн бөгөөд тухай бүр зөвлөмж өгч ажиллажээ.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудитыг цаг тухайд нь хийж зөрчил дахин гаргахгүй байх тал дээр анхаарч ажилласны дүнд өмнөх зөвлөмжийн биелэлтийн хувь өссөн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 онд хэрэгжүүлэх 3 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 237,417.8 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 21,506.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 137,441.2 сая төгрөг, зээлийн төлбөрт 78,469.8 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ батлагдсан дүнгээс 35.1 хувь буюу 83,310.8 сая төгрөгөөр хэмнэлттэй байна. Үүнээс: урсгал зардалд 19,510.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1,996.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 93,368.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 44,073.0 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Эрчим хүчний сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “www.energy.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Эрчим хүчний яам өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломжийг бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр);
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр);
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр);



4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (бүтэн жилээр, хагас жилээр);
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (бүтэн жилээр, хагас жилээр);
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр);
7. Санхүүгийн тайлан (бүтэн жилээр, хагас жилээр);
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (бүтэн жилээр);
9. Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр) зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Эрчим хүчний яамтай холбоотой зөрчил, дутагдал илрээгүй бөгөөд ямар нэгэн зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар:

- Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-иудад Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр “Голден пейж аудит”, “Далайван аудит” ХХК аудит хийсэн байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2017оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг зөрчиж аудит хийлгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчид харьяа газруудын санхүүгийн тайланд аудит хийлгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулахдаа Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журмыг баримтлах талаар албан шаардлага хүргүүлэх.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд авлага өмнөх оноос 1,774.1 сая төгрөгөөр өсч 99,185.7 сая төгрөгийн, өглөг 16,652.4 сая төгрөгөөр өсч 110,283.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дэх хэсэгт “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Систем хоорондын авлага өмнөх оноос 2,255.8 сая төгрөгөөр, өглөг 3,855.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Тухайлбал: “Диспетчерийн үндэсний төв” ХХК 4,989.1 сая төгрөг буюу 31.8 хувь, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК 3,343.4 сая төгрөг буюу 24.8 хувь, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК 2,256.4 сая төгрөг буюу 4.3 хувийг тус тус эзэлж байгаа нийт авлагын өсөлтөд нөлөөлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж давтагдсан, Төсвийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэн авлага, өглөг барагдуулах талаар албан шаардлага хүргүүлэх.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 19 аж ахуйн нэгж байгууллагууд төсөвт төлөх татварын өглөг 2,572.8 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 830.2 сая, ногдол ашгийн өглөг 660.2 сая, дансны өглөг 4,850.1 сая, нийт 8,913.3 сая төгрөгийн өглөгийг мөнгөн хөрөнгийн 45,650.4 сая төгрөгийн үлдэгдлээс барагдуулах боломжтой байсан ба барагдуулах арга хэмжээ аваагүй нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар бүлгийн 21.4-т “Албан татвар төлөгч энэ хуулийн 21.3-т зааснаар хүргүүлсэн хуваарийн дагуу сар бүрийн 25-ны дотор албан татварыг урьдчилан төлж, татвар төлөлтийн улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-т “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх өглөгийг барагдуулах талаар албан шаардлага хүргүүлэх.

- Холбогдох удирдлагын шийдвэргүйгээр шатахуун нийлүүлдэг компанитай 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 458 тоот үйлчилгээ үзүүлэх 7.6 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан, Маягт нийлүүлдэг 2 компаниас сонгон шалгаруулалтгүй, гэрээ байгуулалгүй 9.8 сая төгрөгийн бараа материал худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, “12.1-т “Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Барилга барих, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, автомашин зэрэг 2,862.4 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авахдаа сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1, 8.5, 12.1, 17.1, 20.1, 21.3, 33.2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Тухайлбал: “Алтай улиастайн эрчим хүчний систем” ТӨХК аваарийн нөөц бүрдүүлэх сэлбэгт 14.9 сая төгрөг, “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” ТӨХК шатахуунд 41.9 сая төгрөг, “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК барилгын өргөтгөл барих, автомашин худалдан авахад 2,022.8 сая төгрөг, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК бараа материал худалдан авахад 277.5 сая төгрөг, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК бараа материал худалдан авахад 247.0 сая төгрөг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК сэлбэг хэрэгсэл худалдан авахад 203.5 сая төгрөг, “Хөвсгөл дулааны станц” ТӨХК сэлбэг хэрэгсэл худалдан авахад 54.8 сая төгрөг тус тус зарцуулжээ.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө, ажил, үйлчилгээг олж бэлтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

- Эрчим хүчний яамны урсгал зардлаас 874.2 сая төгрөгийн санхүүжилт авдаг 5-н төсөл, хөтөлбөр нь тусдаа санхүүгийн мэргэжилтэнтэй боловч үндсэн цалин болон үйл ажиллагааны гүйлгээ, татвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг яамны урсгал зардалт харилцааны мэргэжилтэн хэрэгжүүлж, ажил үүргийг давхар гүйцэтгэж төсөвт зардлыг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх, ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, ажлын байрны давхардлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар зөвлөмж хүргүүлэх.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгдсэн “Эрчим хүчний системийн үр ашиг” төслийн 4,047.4 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй байхад зарцуулснаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

- Харьяа зарим байгууллагуудын санхүүгийн тайлангийн эздийн өмч буюу Засгийн газрын хувь оролцоо болон улсын бүртгэлийн гэрчилгээний дүрмийн сангийн дүн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаал баталсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “*Хуулийн этгээд доор дурдсан мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ*”, 4.1.3-т “*хувь нийлүүлсэн хөрөнгө, хувь эзэмшигчийн хувь*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль зүйн сайдын тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

- Харьяа байгууллагуудын зорилтот түвшингийн төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, борлуулалтад мөрдөх үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хороо баталдаг байна. Эдгээр батлагдсан зорилтот түвшингийн төлөвлөгөө болон үнэ тарифын зохицуулалт нь хоорондын уялдаа холбоогүй, үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Зарим харьяа байгууллагууд батлагдсан зорилтод түвшингийн төлөвлөгөөг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох газруудаас баталдаг төлөвлөгөө болон үнэ тарифын зохицуулалтын хоорондын уялдаа холбоог сайжруулах, биелэлтийг хангуулах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар:

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэдэг 6 байгууллагыг түүвэр хэлбэрээр хамруулсан бөгөөд аудитаар нийт 23,365.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 18,426.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 4,939.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 зөвлөмжийг Эрчим хүчний яамны удирдлагад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дээрх байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн нийтлэг алдаа, зөрчлийг дараах байдлаар хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Авлага, өглөгийг барагдуулах талаар арга хэмжээ авах;
- Худалдан авах ажиллагааны талаар;
- Зардлын зарцуулалтын талаар;
- Эздийн өмчийн талаар;
- Зорилтот түвшингийн биелэлтийн талаар зэрэг болно.



Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, бусад холбогдох журмыг тус тус зөрчсөн байна.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрчим хүчний сайдын Үндэсний аудитын газарт ирүүлсэн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь зарим үзүүлэлт болох гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд аудитад хүндрэл учруулав.

Энэ нь зээлдэгч талуудтай холбоотой бөгөөд зээлийн үр дүнтэй холбоотой эрсдэл үүсэх магадлалтай тул холбогдох байгууллага, албан тушаалтнууд анхааралдаа авах нь зүйтэй байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

Эрчим хүчний салбарын 2017-2018 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн талаар судалгаа авч 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хамруулах нь зүйтэй.

Харьяа газруудын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хараат бус аудитын компаниудад чанарын хяналт хийх шаардлагатай байна.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 79,908.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг нэгтгэж, баталгаажуулав.


Үүнээс: Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 23,365.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс, 18,426.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 4,939.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 4 зөвлөмж хүргүүлээ.

Нэгтгэлд хамрагдсан харьяа 38 байгууллага, аж ахуйн нэгж болон шууд захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 56,515.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 28,533.7 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 293.6 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 9 төлбөрийн акт тогтоож, 2,348.6 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага өгч, 25,339.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 127 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажилласан бөгөөд зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 96.3 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн албан бичгээр 01



3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2017 оны батлагдсан төсвийн нийт зардлыг сонгосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 27 төрийн өмчит компаний тайлан нэгтгэгдэж, төсвөөс санхүүжилт авдаггүй байдлыг харгалзан үзэж, 2017 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагыг суурь үзүүлэлт болгон сонгов.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 2 хувь буюу 39,199.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг бус, санхүүгийн нэгтгэсэн тайланд нөлөөл үзүүлэхгүй байгаа нь материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 293.6 сая төгрөгийн санхүүгийн, 20,775.1 сая төгрөгийн санхүүгийн бус үр өгөөжийн тооцооллыг хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Эрчим хүчний яамны Санхүүгийн хэлтсийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Худалдан авах ажиллагааны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Холбогдох удирдлагын шийдвэргүйгээр шатахуун нийлүүлдэг компанитай 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 458 тоот үйлчилгээ үзүүлэх 7.6 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан, Маягт нийлүүлдэг 2 компаниас сонгон шалгаруулалтгүй, гэрээ байгуулалгүй 9.8 сая төгрөгийн бараа материал худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, “12.1-т “Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Барилга барих, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, автомашин зэрэг 2,862.4 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авахдаа сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1, 8.5, 12.1, 17.1, 20.1, 21.3, 33.2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд:

Хууль зөрчигдөх, иж бүрэн байх, хэмжилт зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх

ҮАГ-ын зөвлөмж:

Хөрөнгө, ажил, үйлчилгээг олж бэлтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан болно.



4.2 Зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Эрчим хүчний яамны урсгал зардлаас 874.2 сая төгрөгийн санхүүжилт авдаг 5-н төсөл, хөтөлбөр нь тусдаа санхүүгийн мэргэжилтэнтэй боловч үндсэн цалин болон үйл ажиллагааны гүйлгээ, татвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг яамны урсгал зардал хариуцсан мэргэжилтэн хэрэгжүүлж, ажил үүргийг давхар гүйцэтгэж төсөвт зардлыг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгдсэн "Эрчим хүчний системийн үр ашиг" төслийн 4,047.4 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй байхад зарцуулснаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд:

Хууль зөрчигдөх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, хэмжилт зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх, ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, ажлын байрны давхардлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан болно.

4.3 Эздийн өмчийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Харьяа зарим байгууллагуудын санхүүгийн тайлангийн эздийн өмч буюу Засгийн газрын хувь оролцоо болон улсын бүртгэлийн гэрчилгээний дүрмийн сангийн дүн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаал баталсан "Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хуулийн этгээд доор дурдсан мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ", 4.1.3-т "хувь нийлүүлсэн хөрөнгө, хувь эзэмшигчийн хувь" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд:

Эрх ба үүрэг, иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх

ҮАГ-ын зөвлөмж:

Хууль зүйн сайдын тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан болно.

4.4 Зорилтот түвшингийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Харьяа байгууллагуудын зорилтот түвшингийн төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, борлуулалтад мөрдөх үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хороо баталдаг байна. Эдгээр батлагдсан зорилтот түвшингийн төлөвлөгөө болон үнэ тарифын зохицуулалт нь хоорондын уялдаа холбоогүй, үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Зарим харьяа байгууллагууд батлагдсан зорилтод түвшингийн төлөвлөгөөг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд:

Эрх ба үүрэг, үнэн зөв, хэмжилт, иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх,

ҮАГ-ын зөвлөмж:

Холбогдох газруудаас баталдаг төлөвлөгөө болон үнэ тарифын зохицуулалтын хоорондын уялдаа холбоог сайжруулах, биелэлтийг хангуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Балансын үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,156,146,443.4	1,174,796,035.5
Мөнгөн хөрөнгө	58,009,188.4	65,803,830.9
Авлага	97,411,595.0	99,185,705.1
Урьдчилгаа	66,741,497.8	72,767,980.3
Бараа материал	47,107,525.5	54,549,438.6
Нөөцийн бараа	1,900,661.6	2,236,913.8
Бусад эргэлтийн хөрөнгө	884,975,975.1	880,252,166.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,923,621,159.8	2,099,565,194.1
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	15,467,352.3	14,630,123.3
Урт хугацаат зээл	15,467,352.3	14,630,123.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,908,153,807.5	2,084,935,070.8
Биет хөрөнгө	1,898,451,576.2	2,074,987,033.7
Биет бус хөрөнгө	8,757,154.8	8,651,156.4
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	945,076.6	1,296,880.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,079,767,603.2	3,274,361,229.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР	577,569,510.1	748,417,617.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	128,379,281.5	167,199,011.1
Богино хугацаат зээлийн өглөг	6,528,314.8	16,093,019.1
Өглөг	93,630,852.8	96,704,004.5
Урьдчилж орсон орлого	28,220,113.8	54,401,987.5
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	449,190,228.7	581,218,606.0
Урт хугацаат зээл	449,190,228.7	581,218,606.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,502,198,093.0	2,525,943,612.5
Засгийн газрын хувь оролцоо	2,502,198,093.0	2,525,943,612.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	142,791,019.9	52,569,454.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,169,924,652.2	1,196,158,729.7
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	10,346.1	6,940.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	94,712,047.2	117,615,309.5
Хуримтлагдсан үр дүн	639,406,745.0	703,554,448.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	455,353,282.6	456,038,730.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,079,767,603.2	3,274,361,229.6

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	436,853,387.5	441,086,062.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	301,081,655.4	330,485,453.3
Нийтлэг татварын бус орлого	300,296,910.1	326,437,998.3
Тусламжийн орлого	784,745.3	4,047,455.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,771,732.1	110,600,608.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	308,952,868.7	355,532,884.2
УРСГАЛ ЗАРДАЛ	281,528,166.2	314,304,422.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,488,142.8	296,995,893.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,016,143.8	2,564,382.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	338,314.0	283,628.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	365,466.5	279,021.5
Хангамж, бараа материалын зардал	215,967.7	121,047.4
Нормативт зардал	245.0	5,535.0
Эд хогшил, урсгал засварын зардал	34,129.0	33,519.3
Томилолт, зочны зардал	242,689.3	129,233.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	138,573,657.5	144,999,745.4
Бараа үйлчилгээний бусад зардал	121,701,530.0	148,579,780.0
ТАТААС	16,849,933.3	17,149,933.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	190,090.1	158,595.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,424,702.5	41,228,462.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	127,900,518.8	85,580,172.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	6,354,615.3	5,501,330.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,165,458.6	8,476,694.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	117,089,675.6	82,604,808.6

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,708,988,509.5		1,708,988,509.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	602,982,643.2		602,982,643.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,311,971,152.7		2,311,971,152.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(82,335,099.1)		(82,335,099.1)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	155,472,363.9		155,472,363.9
Тайлант үеийн үр дүн	117,089,675.6		117,089,675.6
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,502,198,093.0		2,502,198,093.0
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,502,198,093.0		2,502,198,093.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(105,359,221.5)		(105,359,221.5)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,396,838,871.5		2,396,838,871.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,517,997.4		1,517,997.4
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	45,008,929.5		45,008,929.5
Тайлант үеийн үр дүн	82,577,814.1		82,604,808.6
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,525,943,612.5		2,525,943,612.5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,020,379,425.8	2,196,815,788.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,864,579,693.7	2,057,115,180.0
Нийтлэг татварын бус орлого	1,863,794,948.4	2,053,067,725.0
Тусламжийн орлого	784,745.3	4,047,455.0
Тусламж, санхүүжилтийн орлого	155,799,732.1	139,700,608.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,767,552,186.4	1,959,988,075.4
УРСГАЛ ЗАРДАЛ	1,767,552,186.4	1,959,988,075.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,730,480,814.1	1,913,579,336.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,236,049.4	191,177,746.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,403,784.0	50,574,055.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,297,299.8	21,071,358.8
Хангамж, бараа материалын зардал	811,016,458.0	1,061,643,609.0
Нормативт зардал	2,703.3	4,489.0
Эд хогшил, урсгал засварын зардал	39,948.5	37,402.0
Томилолт, зочны зардал	243,408.5	127,621.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	704,781,990.8	576,634,931.8
Бараа үйлчилгээний бусад зардал	1,459,171.8	12,308,123.0
Татаас	16,849,933.3	17,149,933.3
Урсгал шилжүүлэг	20,221,439.0	29,258,805.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	252,827,239.4	236,827,713.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,324,747.7	1,413,032.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	199,788,945.8	177,892,728.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	199,788,945.8	177,892,728.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(196,464,198.1)	(176,479,696.1)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(43,398,815.6)	(52,553,374.8)
Бусад эх үүсвэр	7,599,737.2	5,967,618.4
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	27,424,702.5	41,228,462.2
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	23,573,850.3	17,292,531.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	12,964,225.7	7,794,642.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,044,962.6	58,009,188.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,009,188.4	65,803,830.9



5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	237,417,815.2	154,106,982.0	83,310,833.2	64.91
УРСГАЛ ЗАРДАЛ	21,506,722.3	19,510,341.8	1,996,380.5	90.72
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,278,290.4	2,299,230.6	1,979,059.8	53.74
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,933,564.7	1,106,898.4	826,666.3	57.25
Үндсэн цалин	1,599,595.7	775,972.0	823,623.7	48.51
Нэмэгдэл	254,308.7	251,327.9	2,980.8	98.83
Унаа хоолны хөнгөлөлт	79,660.3	79,598.5	61.8	99.92
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,268.4	113,667.1	8,601.3	92.97
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,517.8	71,631.4	9,886.4	87.87
Хангамж, бараа материалын зардал	233,443.9	44,190.4	189,253.5	18.93
Нормативт зардал	2,776.9	2,664.0	112.9	95.94
Эд хогшил, урсгал засварын зардал	25,163.4	24,767.9	395.5	98.43
Томилолт, зочны зардал	35,579.3	35,577.5	1.8	99.99
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,511.9	25,610.8	30,901.1	45.32
Бараа үйлчилгээний бусад зардал	1,787,464.1	874,223.1	913,241.0	48.91
Татаас	17,150,000.0	17,149,933.3	66.7	100
Урсгал шилжүүлэг	78,431.9	61,177.9	17,254.0	78
Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,490.7	1,288.3	3,202.4	28.69
Бусад урсгал шилжүүлэг	73,941.2	59,889.6	14,051.6	81
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	137,441,222.3	93,368,178.0	44,073,044.3	67.93
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	78,469,870.6	41,228,462.2	37,241,408.4	52.54
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	78,469,870.6	41,228,462.2	37,241,408.4	52.54
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	237,417,815.2	154,106,982.0	83,310,833.2	64.91
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	133,128,035.4	108,831,064.7	24,296,970.7	81.75
Улсын төсвөөс санхүүжих	133,128,035.4	108,831,064.7	24,296,970.7	81.75
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	101,223,929.8	41,228,462.2	59,995,467.6	40.73
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	101,223,929.8	41,228,462.2	59,995,467.6	40.73
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	3,065,850.0	4,047,455.0	(981,605.0)	132.02
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	3,065,850.0	4,047,455.0	(981,605.0)	132.02

